



## СҮХБААТАР АЙМГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### “Суралцагч багш” чадавхжуулах сургалт

Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн “СУРАЛЦАГЧ БАГШ” чадавхжуулах сургалт 8 сарын 27, 28 өдрүүдэд болж өндөрлөсөн.

- 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлангийн үнэлгээ, санал дүгнэлт,
- Насан туршийн суралцахуйн салбарын нэгжийн түвшинд хийсэн хэрэглэгчийн үнэлгээний нэгтгэлийг танилцууллаа.



Дээрх сургалтад “Зочин илтгэгч багш”-аар:

5“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийн сургагч багш бэлтгэх, түгээн дэлгэрүүлэх нутагшуулах, тухайн хөтөлбөрийн дагуу сум орон нутагтаа бие даан сургалт явуулах чадвар эзэмших, багш нарын заах арга зүйг сайжруулах зорилгоор

- Төслийн танилцуулга зорилго, арга зүй, үр дүн сэдвээр ЯХИС-ийн төслийн Сүхбаатар аймаг дахь зохицуулагч Ө.Марал



- ESEL сургалтын зохион байгуулагч, онцлог сэдвээр – МБС-ын арга зүйч багш, ESEL хөтөлбөрийн Зөвлөх багш Д.Нямсүрэн, МБС-ийн багш, ESEL хөтөлбөрийн сургагч багш Б.Цогтжаргал нар удирдан зохион байгуулсан.



Орон нутгийн иргэдийн хууль эрх зүй, мэдээллийн технологийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулахад шаардлагатай арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дараах сургалт зохион байгуулагдсан.

- “Видео эвлүүлэг хийх хялбар арга зам” – Зочин багш Баруун – Урт сумын 1-р сургуулийн Монгол улсын зөвлөх багш О.Оюунтунгалагаар ахлуулсан баг хамт олон.
- “Зөрчлийн тухай хууль түүний хэрэгжилт”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, түүний хэрэгжилт” – Зочин багшаар Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын Цагдаагийн хошууч Б.Сугаржав
- “Стресс менежмент, ажлаас халшрах хам шинж” – Зочин багш Баруун – Урт сумын 1-р сургуулийн сэтгэл зүйч Б.Ануу



### “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалт

ЕБС-ын 8-12-р ангийн суралцагчид болон эцэг эх асран хамгаалагчид, анги удирдсан багш нарт зориулсан

- Мэргэжлээ сонгоход хувь хүний анхаарах асуудал
- Хичээл сонголт ба Мэргэжил
- Мэргэжил сонголт ба Тэтгэлэг боломж сэдэвт сургалтуудыг Насан туршийн суралцахуйн төв нь Баруун – урт сумын 1-р сургууль, 3-р сургуулиудад зохион байгуулан ажиллаж байна.



### “Угийн бичгийн сургалт”

Сүхбаатар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт “Аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээнэ” гэж заасны дагуу аймгийн хэмжээнд “Угийн бичиг” хөтлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор, монголын уламжлалт соёлын биет бус өвийн нэг хэлбэр болох “Угийн бичиг” хөтлөх ажлыг өвлүүлэн уламжлуулж, түгээн дэлгэрүүлэх, эрхэмлэх эрмэлзлэлийг төрүүлж, байгууллага, хувь хүн, гэр бүлийн хамтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор зохион байгуулагдаж буй аяны хүрээнд Төрийн болон төрийн бус байгууллагуудад “Угийн бичиг хөтлөх аргачлал” сургалт зохион байгуулагдаж байна.



Онцгой байдлын газар, 3-р цэцэрлэг, Стандарт хэмжил зүйн хэлтэс, 1-р цэцэрлэгийн эцэг, эхийн төлөөлөл, 11-р цэцэрлэгийн эхийн төлөөлөл, Мал эмнэлэг, Орон нутгийн өмчит газар, Татварын хэлтэс, Соёлын газар зэрэг нийт 9 байгууллага хамрагдав.



### “Цахим орчинд – Хос бичгээр мэдээлэл бэлтгэх арга зүй”

Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага Төрийн албан хэргийг хос бичгээр хөтөлнө.

Энэ хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн албан хаагчийн үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвар, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Насан туршийн суралцахуйн төвөөс төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн анхан болон дунд шат, Цахим орчинд хос бичгээр мэдээлэл бэлтгэн оруулах арга зүйн сургалтуудыг зохион байгуулж байна.



## 2024-2025 оны багш нарын бага хурал

Сүхбаатар аймгийн 12 сум сургуулийн Насан туршийн суралцахуйн багш нар Аймгийн багш нарын "Бага хурал"-даа оролцлоо.



## “Насан туршдаа суралцахуй – Хамтдаа суралцъя” хичээлийн шинэ жилийн нээлтийн өдөрлөг

Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн төв нь 2024 - 2025 оны хичээлийн жилийн "НАСАН ТУРШДАА СУРАЛЦАХУЙ - ХАМТДАА СУРАЛЦЪЯ" нээлтийн үйл ажиллагааг 2024.09.02-ний өдөр төв талбайд зохион байгууллаа. Тус нээлтийн үеэр 5 төрлийн рийл, 6 төрлийн богино хэмжээний видео контент бэлтгэн фэйж хуудсаараа нийтлэв.



## “Найрсаг Баруун-урт” өдөрлөг

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Найрсаг Баруун-Урт" өдөрлөгт Насан туршийн суралцахуйн төв оролцов. Өдөрлөгийн хүрээнд:

- Боловсрол нөхөн эзэмших боломж
- Бичиг үсгийн боловсрол олгох сургалт
- Санхүүгийн боловсрол ба Хуримтлал



- Хүүхэд хамгаалалын бодлого хэрэгжилтэд иргэдийн үүрэг оролцоо сэдвийн хүрээнд иргэдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн гарын авлага, тараах материалыг олны хүртээл болгож байна.



### “Суралцагч аймаг – 3.7.3” уралдаан

УИХ-ын гишүүн асан Наянтайн Ганибалын ивээн тэтгэлгээр зохион байгуулсан "Суралцагч аймаг-3.7.3" уралдаан дүнгээ гаргаж шагналаа гардууллаа. Уралдаан 8 сарын турш үргэлжилсэн бөгөөд 11 сумын 17 суралцагч байгууллага, 60 хамт олон, 27 иргэн нийт 2000 гаруй иргэн 105 төрлөөр оролцож өрсөлдлөө.



"Зорилготой хуримтлуулъя" уриатайгаар зохион байгуулагдаж буй "Дэлхийн хуримтлалын өдөр - 2024" аяны нээлтийн үйл ажиллагаа Сүхбаатар аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Тус аяныг Сүхбаатар аймаг дахь Монгол банк, банкны салбаруудтай хамтран зохион байгуулах бөгөөд аяны хүрээнд сургалт нөлөөллийн ажлууд, гар зургийн болон бусад төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулахаар төлөвлөөд байна.



Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-тай хамтран цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадварын III үе шатны сургалтыг “Цахимд зөв байя” төрийн албан хаагчдад зориулсан сургалтад хамрагдсан.

Баруун-Урт, Халзан, Эрдэнэцагаан, Наран, Дарьганга сумын Насан туршийн суралцахуйн багш нар тэтгэвэрт гарах, өөр ажилд шилжсэн шалтгаанаар сул орон тоо гарснаар нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж хангалттай оноо авч тэнцсэн 3 багшийг тухайн сургуулийн удирдлагад уламжилсны дагуу шинээр томилогдсон. Эрдэнэцагаан сумын багшийн сонгон шалгаруулалтад шалгуур хангах хүн ирээгүй болно.

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

Сүхбаатар аймгийн Наран, Халзан сумын Насан туршийн суралцахуйн багшийн ажлын байранд урьж байна.

**Түнээвэр шаардлага:**

- Бага бэлтгэл нь дээд сургууль төгссөн
- Багаханх эрхтэй байх /2019 оноос өмнөх оны төгсөгчид ИМДН-ийн үндсэн сургалтад хамрагдсан /
- Мэдээлэл харилцаа технологийн ур чадвартай
- Судалгаа, илтгэлтэй хийж, илтгэх чадвартай
- Гаднах хэлний зохио мэдэртэй

**Сонгон шалгаруулалтад өрсөлдөхөд иргэд нь дараах шаардлагыг бүрхүүлнэ.**

- Цэргийн үнэмлэх /хуульчдын хамт/
- Төрийн албан хаагчийн амжилт
- Мэргэжлийн амжилт /хуульчдын хамт/
- Багаханх эрхийн үнэмлэх/үндсэн сургалтын сертификат /хуульчдын хамт/
- Мэргэжлийн бэлтгэл /хуульчдын хамт/
- Мэргэжлийн бэлтгэл /хуульчдын хамт/
- Амжилттай ажлын үр дүнд хуульчдын хамт/
- Амжилттай ажлын үр дүнд хуульчдын хамт/

**Бүртгэл:** 2024 оны 09 дугаар сарын 09-нөөс 09 дугаар сарын 12-ны хооронд ажлын өдрүүдэд ажлын цагаар Насан туршийн суралцахуйн төвд хийгдэнэ.

**Хувиар бүртгэх утас:** 99000007, 99628586, 70518227

**Сонгон шалгаруулалт:** 2023 оны 09-р сарын 13-ний Басалга гаралтын 09.00 цагийн Насан туршийн суралцахуйн сонгон сургалтын цахимд болно.

**НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВ**